



СОЁМБО

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

МЭДЭЭ

№08 /221/

2022.01.10

Цаг үе, үйл явдал

ОЮУТНУУД ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ТАНИЛЦАЖ БАЙНА



ЗХЖШ АШУУИС-тай хамтын ажиллагааны гэрээ байгуулсан бөгөөд үүний хүрээнд тус сургуулийн оюутнуудтай "Оюутан цэрэг-нэг өдөр" сурталчилгааны арга хэмжээг өнөөдөр Зэвсэгт хүчний 084, 150, 350 дугаар ангиудад явуулж байна. АШУУИС-ийн оюутнууд энэхүү арга хэмжээний хүрээнд Зэвсэгт хүчний нэг өдрийн үйл ажиллагаатай танилцаж, цэрэг эх оронч үзэл сэдэвт лекц, ангийн бие бүрэлдэхүүнтэй хамтарсан тэмцээн уралдаан зэрэг үйл ажиллагаанд хамрагдах юм.

Түүхэнд энэ өдөр

1939 он.

Монгол Улсын халхын голын хил орчмоор Япон, Манж-Го улсын цэргүүд зэвсэгт өдөөн хатгалга хийж эхлэв.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-14	-31

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
37	22

АРТИЛЛЕРИЙН ЦЭРГИЙН ХОЛБООНЫ БАГ ТАМИРЧИД ШИЛЖИН ЯВАХ ЦОМОО ХАДГАЛАВ



БХЯ-ны ахмадын хорооны санаачилгаар жил бүр уламжлагдан явагддаг Төрөл мэргэжлийн холбоодуудын гар бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээнийг 2019 оны аварга баг Монголын Артиллерийн цэргийн холбоо зохион байгуулж явууллаа. Тус тэмцээн 2020 онд цар тахлын улмаас хойшлогдож, 2021 оны тэмцээнийг энэ оны 1 дүгээр сарын 8-нд буюу өнгөрсөн Бямба гарагт амжилттай зохион байгуулав.

Тэмцээнд Артиллерийн цэргийн холбоо, Ерөнхий цэргийн ассоциаци /2 баг/, БХЯ-ны ахмадын хороо, Цэргийн улс төр, соёл хүмүүжлийн ажилтны нэгдсэн эвлэл, Инженерийн цэргийн холбоо, Зенитчдын холбоо, Энх тэнгэрийн харуул, Цэргийн зэвсгийн холбоо, Барилгын цэргийн холбоо,

Цэргийн биеийн тамир, спортын холбоо, Хуягт танкны холбоо, Ар талын ажилтны холбоо баг тамирчдаа бэлтгэж нийт 13 баг тамирчин тэмцээнд оролцлоо.

Зохион байгуулалтын өндөр түвшинд явагдсан эл тэмцээнд Артиллерийн цэргийн холбооны баг тамирчид 2 дахь удаагаа тэргүүлж шилжин явах цом, өргөмжлөл, алтан медалийн эзэд болсон бол дэд байрт Ерөнхий цэргийн ассоциацийн баг шалгарч өргөмжлөл, мөнгөн медаль хүртэв. Харин гутгаар байрт Цэргийн биеийн тамир, спортын холбооны баг шалгарч хүрэл медаль, өргөмжлөлөөр шагнууллаа.

Цар тахлын улмаас тэмцээнийг үзэгч, хөгжөөн дэмжигчгүйгээр зохион байгуулсан юм.

ЦЭРГҮҮДЭЭ ЭРГЭЛЭЭ



Баянгол дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штаб

Баянгол дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн "Засаглалын бодлого", ЗДТГ-ын Цэргийн штабын "Сургалт бэлтгэлийн нэгдсэн төлөвлөгөө"-ний дагуу 2021 онд тус дүүргээс Зэвсэгт хүчин болон Хилийн цэрэг, Дотоодын цэргийн ангиудад хугацаат цэргийн албанд татагдсан цэргийн алба хаагчдыг эргэх, ангийн үйл ажиллагаа, орчин нөхцөлтэй нь танилцах арга хэмжээг зохион байгууллаа.

Тодруулбал, тус дүүргийн Засаг дарга бөгөөд Батлан хамгаалах товчооны дарга Ө.Сумъяабаатар, ЗДТГ-ын дарга бөгөөд Цэрэг татлагын

товчооны дарга Б.Нарангэрэл, ЗДТГ-ын Цэргийн штабын дарга хурандаа Л.Цэрэгбаяр нар Зэвсэгт хүчний 032, 120 дугаар ангиудад алба хааж байгаа дайчидтай уулзаж, тэдэнд шинэ жилийн бэлэг гардуулсны зэрэгцээ ар гэрийнхэнтэй нь "Цахим уулзалт" зохион байгуулан "Иргэн-цэрэг"-ийн харилцааг бэхжүүлэн ажиллалаа. Мөн Баянгол дүүргийн Засаг дарга Ө.Сумъяабаатар Зэвсэгт хүчний 032, 120 дугаар ангиудын номын сангийн фондыг баяжуулах, нэр төрлийг олшруулах, алба хааж буй дайчдын мэдлэгийг тэлэх зорилгоор анги тус бүрд зургаан нэр төрлийн 30 гаруй ном бэлэглэн дээрх ангиудад орон нутгаас татагдсан хугацаат цэргийн алба хаагчдад гарын бэлэг гардуулан өглөө.

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,846.0	2,851.0
EUR	3,222.0	3,235.0
CNY	431.00	436.10
RUB	36.38	38.43
JPY	24.70	24.80
KRW	2.37	2.39

ЗУРХАЙ

2022.01.10 ДАВАА ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 8/

ӨВЛИЙН АДАГ ЦАГААГЧИН ҮХЭР САР ХОЁР ХАР МЭНГЭТЭЙ ХАРАГЧИН ГАХАЙ ӨДӨР

Үс засуулбал:

Нас уртасна

НАРАН УРГАХ, ШИНГЭХ: 08.40-17.19

БАРИЛДЛАГА: Үл зохилдох

ШҮТЭН БАРИЛДЛАГА:

Хурьцахуй

Суудал: Хий

Тухайн өдөр нохой, хонь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Өдрийн сайн цаг нь үхэр, луу, морь, хонь, нохой, гахай болой. Эл өдөр андгай тангаргаас няцах, дайсныг номхруулах үйлд сайн. /муу найз нөхрөөс холдож салахад ээлтэй өдөр/, бурханы үйл, хувцас хийхэд сайн. Зүүн нүд татвал хувцас олох, баруун чих цангинвал үзэсгэлэн болох, зүүн нь бол үхэл болсныг сонсох, нохой улвал сонсголонтой үг сонсох, тагнай загатнавал гэр арвидах, бие татвал 1-2 хүн ирэх, хөл татвал гомдол агуул болно.

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

ВАКЦИНЖУУЛАЛТ I ТУН 2,266,992 /69.7%/	ВАКЦИНЖУУЛАЛТ II ТУН 2,166,296 /66.6%/	ДАРХЛАА СЭРГЭЭХ ТУН 936,906 28,8%
--	---	--------------------------------------

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН 7374 +112	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ 222	ЭДГЭРСЭН 7034
------------------------------	----------------------------	------------------

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол Нийт: 307,883,849
Эдгэрсэн Нийт: 259,529,451
Нас барсан Нийт: 5,505,854



Цахим шууданд

ЭРХ ЗҮЙН МЭДЛЭГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ СУРГАЛТУУД ҮРГЭЛЖЛЭВ



хаагчдын нийтлэг гаргадаг алдааг хөрөнгө орлогын мэдүүлгийн загвар бүрд нь тодорхой тайлбар өгсний дээр "Авлигын эсрэг хууль", "Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль"-ийн талаарх сургалтыг нэмж явууллаа. Үүний дараа Захиргааны удирдлагын хэлтсийн нууцын офицер ахмад Ч.Цогбадрах нууц хадгалалт,

Долоо хоногийн төлөвлөгөөний дагуу өнгөрөгч Баасан гаригт ХЗЦК-ын бүрэлдэхүүнд "Хөрөнгө орлогын мэдүүлгийг хэрхэн гаргах", "Нууц хадгалалт, хамгаалалтыг сайжруулах нь" сэдэвт сургалтууд явагдав. Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг эрх бүхий албан тушаалтан жил бүрийн 2 дугаар сарын 15-ны дотор шинэчлэн гаргаж, Авлигатай тэмцэх газарт хүргүүлдэгтэй холбогдуулан мэдүүлгээ хэрхэн үнэн зөв бөглөх, юунд анхаарах, нийтлэг гаргадаг алдаануудын талаарх мэдээллийг тус командлалын Захиргааны удирдлагын хэлтсийн хуулийн офицер ахлах дэслэгч Д.Отгонгэрэл өгсөн юм. Тэрээр "Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Мэдүүлэг гаргагч хөрөнгө, орлогын мэдүүлгээ тухайн албан



тушаалд томилогдсон буюу сонгогдсон өдрөөс хойш 30 хоногийн дотор, цаашид тухайн алба хааж байгаа хугацаандаа жил бүрийн 2 дугаар сарын 15-ны дотор шинэчлэн гаргаж энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасан байгууллага, албан тушаалтанд өгөх үүрэгтэй" гээд шалтгаан бүрээр нь тайлбарлав. Мөн тэрээр алба

хамгаалалтыг хэрхэн хангах талаар мэдээлэл, анхааруулга өгч, төгсгөлд нь Хуурай замын цэргийн штабын дарга, бригадын генерал Л.Онцгойбаяр офицер, ахлагч нарт цэргийн алба зохион байгуулалт, сахилга хариуцлага, дэг журам, ёс зүйн асуудлыг чанд баримтлан ажиллах талаар тодорхой үүрэг өгсөн юм.

МАРШИЙГ ХИЧЭЭЛИЙН ГУРВАН ЦЭГЭЭР ТӨЛӨВЛӨН ЗОХИОН БАЙГУУЛАВ



Зэвсэгт хүчний 014 дүгээр анги
2021-2022 оны сургуулийн жилийн сургалтын төлөвлөгөөний дагуу байнгын бие бүрэлдэхүүн, цэргийн гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчидтай тактик

тусгай бэлтгэлийн цогцолбор 30 км-ийн явган маршийг хичээлийн гурван цэгээр төлөвлөн үйлдлээ. Ингэхдээ буудлагын цэгт офицерууд СБД-1, ахлагч нар буудлагын анхны дасгал-2, хугацаат цэргийн алба хаагчид буудлагын

анхны дасгал-1-ийг тус тус боловсруулах, тактикийн ажиллагаа болон хорлон сүйтгэх бүлгийн ажиллагаа, хордсон газар орныг туулах ажиллагаа зэрэг сургалтуудыг амжилттай зохион байгууллаа. Дэслэгч Р.БИЛЭГ

АНГЛИ ХЭЛНИЙ СУРГАЛТАА ЭХЛҮҮЛЭВ



Зэвсэгт хүчний 350 дугаар анги

Ангийн сургалт бэлтгэлийн төлөвлөгөөний дагуу офицеруудын гадаад хэлний мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор энэ сарын 7-ны өдрөөс англи хэлний дугуйланг хичээллүүлж эхлээд байна. Хичээлийг долоо хоног бүрийн Пүрэв гаргт англи хэлний туслах багш Б.Од-Эрдэнэ удирдан явуулах юм.

"ЭРҮҮЛ АГААР-ЭРҮҮЛ МЭНД" ӨДӨРЛӨГИЙГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Хөл бөмбөгийн тэмцээнд мотобуудлагын батальоны баг тэргүүн байрт шалгарсан бол танкийн батальоны баг удаах байрыг эзэллээ. Уулын оргил булаалдах хөгжөөнт буухиа тэмцээнд автын алба тэргүүн байр эзэлж, штабын баг удааллаа. Цасны сумо бөхийн тэмцээнд эрэгтэйчүүдээсахлахлагч П.Даваадалай тэргүүлсэн бол энгийн С.Мөнгөнчимэг эмэгтэйчүүдээ тэргүүллээ. Тэмцээний төгсгөлд нэгтгэлийн захирагч бригадын генерал Т.Лодойдамба бие бүрэлдэхүүнд баяр хүргэж шагналыг гардуулав.

Түүнчлэн хугацаат цэргийн алба хаагчдын сэтгэл зүйг дэмжих зорилгоор нэгтгэлийн офицер, ахлагч, ажилтан албан хаагч бүрд нэг хугацаат цэргийн алба хаагчийг алба хаах хугацаанд нь хариуцуулан өгч шаардлагатай зүйлсээр дэмжлэг үзүүлж, ар гэрийнхэнтэй нь холбоонд оруулж, баярын өдрүүдэд гарын бэлэг өгснөөр хугацаат цэргийн алба хаагчдын сэтгэл зүйд эергээр нөлөөлж цаашид албандаа хандах хандлага, сэтгэл зүйн тогтвортой байдлыг хангасан үр дүнтэй ажил болж байна.

Хошууч Д.ДОЛГОРЖАВ

Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэл

Нэгтгэлийн 2021-2022 оны сургуулийн жилийн сэтгэл зүйн хангалтын төлөвлөгөөний дагуу алба, салбар сурталчлах аяны хүрээнд ар талын албыг сурталчилж, нэгтгэлийн

"Цасны баяр"-ын арга хэмжээг зохион байгуулж явууллаа. Энэ үеэр цасны сумо, хөл бөмбөг, уулын оргил булаалдах хөгжөөнт буухиа тэмцээнүүдийг зохион байгуулж нэгтгэлийн бие бүрэлдэхүүн нэг өдрийг эрүүл агаарт спортоор хичээллэж өнгөрүүлэв.

ХУГАЦААТ АЛБАНЫ ДАЙЧИД ХЭЭРИЙН СУРГУУЛИАР...



Зэвсэгт хүчний 327 дугаар анги

Ангийн 2021-2022 оны сургуулийн жилийн сургалтын төлөвлөгөөний дагуу хугацаат цэргийн алба хаагчидтай тактик, тусгай бэлтгэлийн цогцолбор 30 км-ийн явган маршийг энэ сарын 7-ны өдөр зохион

байгууллаа.

Энэ удаагийн сургалтаар хугацаат албаны дайчдыг "Тактикийн ажиллагаа, хордсон газар орныг туулах, цувааны хамгаалалт авах, минэжүүлсэн газар орон, гүүрээр гарах" гэсэн сэдвийн хүрээнд дадлагаар үүрэг

гүйцэтгүүлэв. Мөн сургалтын төвийн районд галын бэлтгэлийн нормативыг 3 цэгт зохион байгуулахын зэрэгцээ тасаг, тоотын байлдааны буудлага, батарейны нэгдсэн дадлагыг амжилттай явуулсан юм.

Ахмад Э.МӨНХБАЯСАХ

